

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 15
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	16 – 42

*Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл*

1. /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Д.Энхтүвшин,
Х.Тэмүүжин, Х.Баасанжаргал нарын гишүүд өргөн мэдүүлсэн,
нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

16 – 42

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 18-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 59 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, Т.Доржханд,
Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, Ө.Шижир, Д.Энхтуяа;
Чөлөөтэй: Э.Болормаа, Ц.Даваасүрэн, Ч.Лодойсамбуу, Б.Найдалаа,
О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Д.Энхтүвшин, Х.Тэмүүжин, Х.Баасанжаргал нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийг зүйл бүрээр үргэлжлүүлэн хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Жавхлан: 8.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсгийн “үг хэлж” гэснийг “танилцуулга” гэж, “үг хэлэх” гэснийг “танилцуулга, мэдээлэл хийх” гэж өөрчилж, “Улсын Их Хурлын гишүүн бус Ерөнхий сайдын суудлыг энэ хэсэгт байрлуулна.” гэсэн 2 дахь өгүүлбэрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.10 дахь хэсгийг 15.10, 15.11, 15.12 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн дугаарыг өөрчлөх:

“15.10.Улсын Их Хурлын гишүүн биш Ерөнхий сайд, засгийн газрын гишүүний суудлыг энэ зүйлийн 15.9-д заасан хэсэгт байрлуулна.

15.11.Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын чуулганд Ерөнхий сайд, засгийн газрын гишүүний хувиар оролцож байгаа бол энэ хуулийн 41.2-т заасан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаа хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 27 дугаар зүйлийн 27.15 дахь хэсгийн “Дэд хорооны бүрэлдэхүүнд” гэснийг “Халдашгүй байдлын дэд хорооноос бусад дэд хорооны бүрэлдэхүүнд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 5

Бүгд: 17

70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Б.Жавхлан: 11 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсгийг нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийн “эцсийн хэлэлцүүлгийн” гэснийг “хууль, тогтоол батлах, эцэслэн батлах хэлэлцүүлгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18

72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалт буюу 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18

72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Б.Жавхлан: 14 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 25.7 дахь хэсгийн “сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно” гэснийг “сонгоно” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18

72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.10 дахь хэсгийг 15.10,

15.11, 15.12 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн дугаарыг өөрчлөх:

“15.10.Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд, засгийн газрын гишүүний ажлыг хавсран хийж буй бол нэгдсэн хуралдааны танхимын дунд байрлах мэтгэлцэх индэрийн харалдаа нүүрэн хэсэгт сөрөг хүчний намын даргын суудалтай харгалзуулан Ерөнхий сайдын суудлыг, Засгийн газрын гишүүдийн суудалтай бөөнд нь хуваарилна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 14

Бүгд: 18

22.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

16.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.5, 15.6, 15.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.5.Нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн зүүн гар талд олонхын бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд нүүрний эгнээнд олонхын бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргын суудлын дараагаас, олонхын бүлгийн дарга, эрх барих хүчнээс сонгогдсон Ерөнхий сайд хэрэв Улсын Их Хурлын гишүүн бол түүний суудлыг дарааллуулан хуваарилна. Олонхын бүлгийн бусад гишүүд нэгдсэн хуралдаанд хүрэлцэн ирсэн дарааллаараа олонхын бүлгийн гишүүдэд хуваарилагдсан бусад аль ч суудалд сууж хуралдаандаа оролцож болно.

15.6.Нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн баруун гар талд хамгийн олон суудал авсан цөөнхийн бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд нүүрний эгнээнд тус бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргын суудлын дараагаас цөөнхийн бүлгийн даргын суудлыг хуваарилна. Хамгийн олон суудал авсан цөөнхийн бүлгийн бусад гишүүд нэгдсэн хуралдаанд хүрэлцэн ирсэн дарааллаараа цөөнхийн бүлгийн гишүүдэд хуваарилагдсан бусад аль ч суудалд сууж хуралдаандаа оролцож болно.

15.7.Цөөнх болсон бусад нам, эвслийн бүлгийн гишүүд, бүлэггүй цөөнхийн гишүүдийг дараагийн суудлуудад хуваарилах бөгөөд тус цөөнхийн бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд дарга, тухайн цөөнхийн бүлгийн дарга нарын суудлыг нүүрний эгнээнд тус тус хуваарилна. Цөөнх болсон бусад нам, эвслийн бүлгийн болон бүлэггүй цөөнхийн бусад гишүүд нэгдсэн хуралдаанд хүрэлцэн ирсэн дарааллаараа тэдгээрт хуваарилагдсан бусад аль ч суудалд сууж хуралдаандаа оролцож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 17
Бүгд: 18

5.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Жавхлан: 17.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын “томъёоллоо” гэсний дараа “хуулийн шаардлагад нийцүүлэн томъёолж,” гэж”, гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлд “8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын “зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо холбогдох Байнгын хороонд ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө” гэснийг “зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо хуулийн шаардлагад нийцүүлэн томъёолж, холбогдох Байнгын хороонд ажлын нэгээс доошгүй өдрийн өмнө” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 10
Бүгд: 18
44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

18.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “21 дүгээр зүйлийн 21.20 дахь хэсгийн “мэтгэлцээн явуулна.” гэсний дараа “Мэтгэлцээн явуулах журмыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тогтооно.” гэснийг хасч 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмж, нэгтгэсэн төслийн холбогдох дугаарыг өөрчлөх:

“21.20.Нам, эвслийн бүлэг эсхүл Улсын Их Хуралд суудал бүхий намаас мэтгэлцээн явуулах санал гаргасан бол чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх эсэх үе шатанд мэтгэлцээн явуулна. Мэтгэлцээн явуулах журмыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 10
Бүгд: 18
44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

19.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн мөн зүйлийн 27.8 дахь хэсгийн “саналыг баримтална.” гэсний дараа “Ёс зүйн дэд хороо есөн гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын дэд дарга нар заавал орно.” гэснийг ““саналыг баримтална.” гэсний дараа “Ёс зүйн дэд хороо есөн гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь

Улсын Их Хурлын дэд дарга нар орно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20. Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “мөн зүйлийн 27.10 дахь хэсгийн “сонгоно.” гэсний дараа “Ёс зүйн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын аль нэг дэд даргыг дэд хорооны гишүүд дотроосоо сонгоно.” гэж гэснийг хасаж, нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлд “мөн зүйлийн 27.10 дахь хэсгийн “сонгоно.” гэснийг “эсхүл Улсын Их Хуралд суудал бүхий намын гишүүдээс сонгоно. Ёс зүйн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын аль нэг дэд даргыг дэд хорооны гишүүд дотроосоо сонгоно.” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, А.Ариунзаяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 10

Бүгд: 18

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

21. Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан, Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “мөн зүйлийн 27.8 дахь хэсгийн “саналыг баримтална.” гэсний дараа “Ёс зүйн дэд хороо есөн гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын дэд дарга нар заавал орно.” гэж,” гэснийг хасаж, нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлд “27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсгийн “нам, эвслийн бүлгийн саналыг баримтална.” гэснийг “нам, эвслийн бүлэг, эсхүл Улсын Их Хуралд суудал бүхий намын саналыг баримтална. Ёс зүйн дэд хороо есөн гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын дэд дарга нар орно.” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 16

Бүгд: 18

11.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

22. Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “44 дүгээр зүйлийн 44.1.13 дахь заалтын “ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл” гэсний дараа “хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх,” гэж” гэснийг “44 дүгээр зүйлийн 44.1.13 дахь заалтын “ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл хууль

тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, хянан шалгах чиг үүрэг бүхий ажлын хэсэг, хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах, хууль тогтоомжийн төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргах” гэж өөрчлөн нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйл рүү шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 16

Бүгд: 18

11.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, А.Ариунзаяа, Б.Батбаатар, Ж.Батжаргал нар үг хэлэв.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Жавхлан: 23.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.Олонх Улсын Их Хурлын даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно.

11.2.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлыг Даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно.

11.3.Нэр дэвшигч хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэг авч чадаагүй бол энэ хуулийн 11.1-д заасны дагуу өөр гишүүний нэрийг дэвшүүлж сонгоно.

11.4.Улсын Их Хурлын дарга нь төвийг сахисан, бие даасан байр сууриас бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас өөр албан тушаал давхар эрхлэхийг хориглох бөгөөд гадаад улсад гагцхүү Улсын Их Хурлыг төлөөлнө.

11.5.Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 11.4-т заасан төвийг сахисан, бие даасан байр сууриас бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд намын улс төрөөс ангид байх бөгөөд дараах хязгаарлалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана:

11.5.1.Улсын Их Хурал дахь аль нэг нам, эвслийн бүлгийн хуралдаанд оролцох бол Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн бүлэг, бүлэггүй намын Улсын Их Хурал дахь удирдлагад мэдэгдэнэ;

11.5.2.бүрэн эрхийн хугацаандаа улс төрийн намын даргын сонгуульд өрсөлдөхгүй, намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцохгүй;

11.5.3.хэвлэл, олон нийттэй харилцахдаа Улсын Их Хурлын даргын төвийг сахисан байр суурийг алдагдуулж, улс төрийн намыг төлөөлөх, намын бодлого, ашиг сонирхлыг илэрхийлэхийг хориглоно.

11.6.Энэ хуулийн 11.5-д заасан хориглолт, хязгаарлалт нь Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын дараагийн ээлжит болон ээлжит бус сонгуульд намаасаа нэр дэвшиж, сонгуулийн сурталчилгаа хийх эрхийг хязгаарлахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 17
Бүгд: 18

5.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

24.Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Ж.Батжаргал нарын гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 11 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.6.9 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.9 дэх хэсгийн “цахим хөгжил, хиймэл оюуны бодлогын” гэснийг “Инновац, цахим бодлогын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 10
Бүгд: 18

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

26.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.9.Инновац, цахим бодлогын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

- 23.9.1.дижитал шилжилт, техник, технологийн шинэчлэл;
- 23.9.2.цахим засаглалын бодлого, үйл ажиллагаа, цахим дэд бүтэц;
- 23.9.3.мэдээллийн технологийн хөгжил;

23.9.4. шуудан, сансар, харилцаа холбооны бодлого, үйл ажиллагаа;

23.9.5. хиймэл оюуны хөгжил;

23.9.6. хиймэл оюуны бодлого, хяналт, зохицуулалтын асуудал.

23.9.7. өндөр технологи, инновац, мэдээллийн технологийн үндэсний бодлого;

23.9.8. өндөр технологи, инновац, мэдээллийн технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого;

23.9.9. өндөр технологи, инновацын дэд бүтэц, үйл ажиллагааг хөгжүүлэх бодлого;

23.9.10. өндөр технологи, инновац, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын зах зээлд нэвтрүүлэх хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 12

Бүгд: 18

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

27. Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.3.7, 23.3.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.3.7. шинжлэх ухаан.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 12

Бүгд: 18

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

28. Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэгт “Аж үйлдвэржилтийн байнгын хороо” гэж нэмж, төслийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 11

Бүгд: 18

38.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

29. Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.10.16, 23.10.17, 23.10.18, 23.10.19, 23.10.20 дахь

заалтыг хасаж, нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйл доор дурдсан агуулгатай 23.1 дэх хэсэг нэмж, төслийн дугаарыг өөрчлөх:

“23.1.Аж үйлдвэржилтийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.1.1.хүнд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;
23.1.2.хүнд үйлдвэрлэлийн логистик, дэд бүтэц;
23.1.3.газрын тос, байгалийн хийн асуудал;
23.1.4.түлшний хангамж, нөөцийн бодлого;
23.1.5.ашигт малтмал, түүний суурь судалгаа, хайгуул, ашиглалтын бодлого.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 11
Бүгд: 18
38.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн 22.6.11 дэх заалтын “эрүүл мэнд” гэснийг “хүний хөгжил” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 12
Бүгд: 18
33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

30.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн ““21” гэж” гэснийг ““19” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 13
Бүгд: 18
27.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

31.Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу 46 дугаар зүйлийн 46.5.6.а. дэд заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 16
Бүгд: 18
11.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

32. Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу 46 дугаар зүйлийн 46.5.5 дахь заалтын “хууль зүйн дүгнэлт” гэснийг “хууль зүйн зөвлөмж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 12

Бүгд: 18

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Жавхлан: 33. Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалтын “гэр бүлийн гишүүд” гэснийг “хамаарал бүхий этгээд” гэж” гэснийг “8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалтын “гишүүн хэлэлцэх гэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол тухайн асуудлаар хэлэлцүүлэг, санал хураалтад оролцохоос татгалзах” гэснийг “гишүүн хэлэлцэх гэж байгаа асуудал нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн ашгийн төлөөх үйл ажиллагаанд төрөөс санхүүгийн дэмжлэг авах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхээр бол тухайн асуудлаар хэлэлцүүлэг, санал хураалтад оролцохоос татгалзах” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 10

Бүгд: 18

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Жавхлан: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34. Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн 22 дугаар зүйлийн 22.3.9 дэх заалтын “хууль зүйн зөвлөмж гаргуулах” гэснийг “Байнгын хорооны хүсэлтээр хууль зүйн дүгнэлт, зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээг Тамгын газраар хийлгэх,” гэж” гэснийг “төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргуулах” гэснийг “төсөл болон төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын талаар Байнгын хорооны хүсэлтээр хууль зүйн дүгнэлт, зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээг Тамгын газраар хийлгэх,” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35. Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн “ажиллуулж болох бөгөөд тойргоос сонгогдсон гишүүн бие төлөөлөгч-туслахтай байж болно” гэснийг “, бие төлөөлөгч-туслах тус бүр нэгийг ажиллуулж болно” гэж” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлд шилжүүлэх:

“42.5. Гишүүн батлагдсан төсөвт зардалдаа багтаан зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслах ажиллуулж болно. Тойргоос сонгогдсон гишүүн бие төлөөлөгч-туслах тус бүр хоёрыг ажиллуулж болно. Гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслахын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 9

Бүгд: 18

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Жавхлан: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Жавхлан: **37.**Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

38.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлд “27 дугаар зүйлийн 27.3.7 дахь заалтын “Аялал жуулчлалын хөгжлийн, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн, Инновац, цахим бодлогын хөгжлийн, Тогтвортой хөгжлийн зорилгын” гэснийг “Тогтвортой хөгжлийн зорилгын, Эрчим хүчний хөгжлийн.” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 15 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 35 минут үргэлжилж, 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр 15 цаг 34 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.ЖАВХЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 59 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сарын 18-ны өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг эхлүүлье.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулна.

Одоогоор 32-оос 18 гишүүн ирцдээ орсон байна.

О.Алтангэрэл гишүүн, Ж.Батжаргал гишүүн, С.Бямбацогт гишүүн, Б.Жавхлан гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн, Б.Хэрлэн гишүүн, А.Ариунзаяа гишүүн, Б.Баярбаатар гишүүн, А.Ганбаатар гишүүн, С.Зулпхар гишүүн, Ч.Ундром гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн, Ж.Баярмаа гишүүн, Л.Гантөмөр гишүүн, Л.Мөнхбаатар гишүүн, Н.Учрал гишүүн, Б.Энхбаяр гишүүн. 18 гишүүн ирцэд орсон байна.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулна. Хэлэлцэх асуудал.

Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл үргэлжилнэ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Гурав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Ардчилсан намын завсарлага дууссан байгаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ, Дашцэрэнгийн Энхтүвшин, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Хүрэлбаатарын Баасанжаргал нарын гишүүд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийе.

Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтынхаа ирцэд бүртгүүлнэ үү. 8-аас эхэлнэ шүү.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн ээ, 8 дугаар заалтаас эхэлнэ шүү. 8 дугаар заалтаас эхэлнэ.

Ирцэд орсон гишүүд Ж.Баярмаа гишүүн, А.Ганбаатар гишүүн гишүүн, Л.Мөнхбаатар гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн, Ч.Ундрам гишүүн, Н.Учрал гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Б.Энхбаяр гишүүн санал хураалтын ирцдээ орно уу?

Тэр хооронд Х.Тэмүүжин гишүүнд микрофон өгье.

Х.Тэмүүжин: Тэр 15.6 дээр бид санал хураасан шүү дээ.

Тэрний дараа уг нь нөгөө Б.Батбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал 15.7-д орох ёстой байсан юм. 15.7-д. Тэгсэн чинь бид нөгөө зүйл заалтаа солиод Б.Батбаатар гишүүний саналыг 15.6 руу чихэж оруулах гэж нэг үзээд, тэгээд найруулга нь болохгүй, энэ нэг тийм сонин болчихоод гэж яригдсан шүү дээ.

Тэгэхээр тэрийг 15.7-д санал хураах уу, эс үгүй бол нөгөө гүйцээн боловсруулахыг чуулганы нөгөө нэгдүгээр хэлэлцүүлэг явж байх үед Их Хурлын даргаас аваад дахиад найруулах уу гэдгээ бодохгүй бол нөгөө зүйл, заалт нь андуурагдаж ороод холилдсон нэг тийм санал яваад байгаа.

Б.Батбаатар гишүүн ажлын хэсэг дээр саналаа гаргаад, тэгээд хураалгаад дэмжигдсэн санал байгаа байхгүй юу. Зүйл, заалтаа бид хэд холиод явчихсан байна лээ.

Б.Жавхлан: Гишүүд анхааралтай байгаарай. Б.Пүрэвдорж гишүүн ирцэд орсон байсан боловч орон нутаг руу томилолттой гээд сая чөлөө аваад явлаа.

Тийм учраас манай техникийн албаныхан ирцээс гаргана уу. Өөрөө хүсэлт гаргасан шүү.

Гишүүд анхааралтай байгаарай. Байнгын хороо Ардчилсан намын бүлгийн горимын саналаар завсарлага аваад үргэлжилж байгаа учраас зарчмын зөрүүтэй саналуудаасаа 8-аас эхлээд санал хураалт үргэлжилнэ. Гишүүд анхааралтай. Тэр 8 дээрээ очоорой.

Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулж эхэлье.

8.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсгийн “үг хэлж” гэснийг “танилцуулга” гэж, “үг хэлэх” гэснийг “танилцуулга мэдээлэл хийх” гэж өөрчилж, Улсын Их Хурлын гишүүн бус Ерөнхий сайдын суудлыг энэ хэсэгт байрлуулна гэсэн хоёр дахь өгүүлбэрийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 17 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, тус санал 58.8 хувиар дэмжигдлээ.

9.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.10 дахь хэсгийг 15.10, 15.11, 15.12 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн дугаарыг өөрчлөх:

15.10.Улсын Их Хурлын гишүүн биш Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний суудлыг энэ зүйлийн 15.9-д заасан хэсэгт байрлуулна.

15.11.Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын чуулганд Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний хувиар оролцож байгаа бол энэ хуулийн 41.2-т заасан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаа хамаарахгүй.

Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин.

Х.Тэмүүжин гишүүний микрофон өгье.

Х.Тэмүүжин: Их Хурлын чуулганд Их Хурлын гишүүнээр оролцож байгаа үед адилхан. Их Хурлын гишүүнтэйгээ адилхан. 41.2-т заасан зарчим нь үйлчилнэ.

- Улсын Их Хурлын чуулганд Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний хувиар оролцож байгаа бол,

- Засгийн газраас өргөн барьсан хуулиа танилцуулж байгаа бол,
- төсвөө танилцуулж байгаа бол,
- Улсын Их Хурлын гишүүний асуулгад хариулж байгаа бол,
- Улсын Их Хурлын асуулгын цаг дээр мэтгэлцээнд оролцож байгаа бол –

-энэ 41.2 гэдэг заалт чинь үйлчлэхгүй шүү л гэж хэлж байгаа юм. Бусад үед Улсын Их Хурлынхаа гишүүнийхээ эрхийг эдэлнэ шүү дээ.

Өөр хэн нэгний санаачилсан хууль дээр санал бодлоо илэрхийлэх, үгээ хэлэх бол яг л Улсын Их Хурлын гишүүнийхээ хувиар.

Энд бол Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийхээ хувиар оролцож байгаа бол гэдэг чинь өөр албан тушаалтныхаа хувиар Улсын Их Хуралд оролцож байгаа гэсэн үг шүү дээ.

Б.Жавхлан: Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье. Асуулт. Зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүнээс асуулт.

Энэ чинь ийм дэгээр явж байгаа шүү. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу гээд.

Энэ дээр Б.Энхбаяр гишүүн асуулт.

Б.Энхбаяр: Энэ санал хураах гэж байгаа томъёоллын 15.11 буюу Улсын Их Хурлын чуулганд Засгийн газрын гишүүнийг хавсарч байгаа Улсын Их Хурлын гишүүн оролцож байгаа юм.

Энэ дээр Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын гишүүд хариуцлага хүлээнэ. Улсын Их Хурлын гишүүн бол хариуцлага хүлээхгүй гэдэг агуулга яриад байх шиг байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүнийг хавсарч байгаа Улсын Их Хурлын гишүүн гэдэг ялгаатай эрх зүйн үйлчлээд л хэлсэн үгэн дээр оруулж ирж байгаа юм байна даа.

Ер нь үүний зааг ялгаа гэдэг тийм тодорхойлсон юм байдаг юм уу? Яах вэ, би санааг нь ойлгоод байна л даа. Их Хурлын “гүтгэж, доромжлохоос бусад хэлсэн үгийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй” гэдэг Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаан дээр ийм зааг ялгаа тавиад, Засгийн газрын гишүүд энэ бүрэн эрхийн баталгаа хамаарахгүй гэж. Наад хууль зүйн техникийн хувьд би томъёоллын хувьд. Энэ хэрэглэхэд хэрэглээн дээр их асуудал үүснэ дээ.

→ Мэтгэлцээний шатанд Их Хурлын гишүүн нь давуу эрхтэй байж болдог. Засгийн газрын гишүүд нь яагаад адилхан мэтгэлцэж болдоггүй юм? Байр суурь илэрхийлж болдоггүй юм уу? Өөрийгөө хамгаалж. Тэгээд

дуугүй сууж байх ёстой юм уу?

Парламентын мэтгэлцээн чинь харин энэ мэтгэлцээнийг нь нээлттэй, ил тод, эрүүл байлгахын тухайтад хэлсэн үгийг нь тэгж чи ийм хүрээ рамд л хэлж болно ийм хүрээ рамд хэлж болохгүй -гэж ийм хязгаарлалт тавьж болж байгаа юм уу? Адилхан л алалцаг л дээ. Ард түмэн л хожно шүү дээ. Эрүүл мэтгэлцээнээс.

Үүнийг хэрэглэхэд асуудал үүснэ шүү. Хууль хэрэглээн дээр. Тэгээд Засгийн газрын гишүүн бөгөөд Их Хурлын гишүүн болохоор ам хэл нь үдээстэй байх ёстой. Ер нь тэгээд номхон дөлгөөн загнуулаад явж байх ёстой гэдэг ийм зарчмын байр суурийг хуульчилж болж байгаа юм уу? Аан?

Адилхан дебет хийгээд л байдаг биз дээ? Тэр гаднын парламентууд чинь парламент дээрээ Засгийн газрын гишүүд нь ч гэсэн байр сууриа хамгаалах ёстой шүү дээ. Тийм. Тэгээд загнуулаад байж байх ёстой гэдэг хууль хийж болж байгаа юм уу?

Б.Жавхлан: Хариулт. Хууль санаачлагч Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Хүн загнадаг хүн л ингэж өөрөө уншдаг байх даа. Би уншаад өгөөдөхье. Дахиад.

Улсын Их Хурлын гишүүн биш. Биш. Уучлаарай.

Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын чуулганд Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний хувиар оролцож байгаа бол энэ хуулийн 41.2-т заасан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаа хамаарахгүй гэж.

Улсын Их Хурлын дарга Улсын Их Хуралд мэдээлэл өгч байгаа. Танилцуулга хийж байгаа. Бүх гүйцэтгэх эрх мэдлийн албан тушаалтнууд болон ажлын хэсэгт орсон хүмүүст орж ирэх болгонд нь сануулж байгаа шүү дээ.

- Худал мэдээлэл өгөхгүй шүү гэж.
- Улсын Их Хурлыг хуурахгүй шүү гэж.

Энэ нь өөрөө гүйцэтгэх ерөнхийдлийн бүх албан тушаалтанд хамаатай байхгүй юу.

Яагаад гэвэл Засгийн газар Ерөнхий сайд Улсын Их Хуралд ажлаа хариуцаж байгаа.

Гэтэл Улсын Их Хуралд ажлаа хариуцаж байгаа энэ албан тушаалтнууд давхар дээлийнхээ цаагуур нуугдаад “Улсын Их Хуралд худлаа хэлж болно” гэдэг ийм зарчмыг харин бүүр хуульчилж болохгүй. Яг эсрэгээрээ.

Энд чинь ерөөсөө Улсын Их Хурлыг хуурахгүй шүү, Улсын Их Хуралд худал мэдээлэл өгөхгүй шүү гэдэг л зарчим байгаа. Засгийн газар Улсын Их Хуралд худал мэдээлэл өгөөд эхлэх юм бол Улсын Их Хурал буруу шийдвэр л гаргана гэсэн үг шүү дээ.

Ард түмнийг төлөөлж байгаа институт буруу шийдвэр гаргахгүйн тулд –

- хамгийн их мэдээлэлтэй,
- хамгийн их захиргааны бүтэцтэй,
- хамгийн их төсөвтэй –

-тэр институтээс үнэн мэдээллийг шаардах эрхтэй. Энэ үнэн мэдээллийг өгөх албан тушаалтан нь өөрөө Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд өөрсдөө.

Тийм учраас энэ хуулийг харангуутаа бидний худлаа ярихыг хориглоод байгаа юм биш үү гэдэг байр сууриас харж байгаа бол угаасаа бид худлаа ярина гэдэг цаанаа тийм итгэл үнэмшилтэй байна гэсэн үг шүү дээ. Ийм зүйл дээр эмзэгнэж байгаа бол.

Бусад асуудал дээр. Өөрөөр хэлбэл Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүнийхээ хуваарь ороогүй чуулган дээрээ асуудлууд дээрээ Улсын Их Хурлын гишүүнийхээ энэ эрхийг эдэлнэ шүү дээ.

Энэ чинь Улсын Их Хурлын 126 гишүүн бүхий Улсын Их Хурлын бусад гишүүдээс та нар –

- хүн томилдог,
- төсөв зарцуулж зардаг,
- мэдээлэл авдаг тийм давуу эрхтэй хүмүүс шүү дээ.

Энэ давуу эрхээ хууль бусаар ашиглахгүйн тулд, худал ярихгүйн тулд энэ давуу эрх эдэлж байгаагийнхаа хувьд Улсын Их Хурал дээр энэ давуу эрхээр оролцож ирж байгаа чуулганы тэр хэсгүүд дээр энэ эрхээ хязгаарлуулах гэдэг чинь шударга ёс шүү дээ.

Бусад Улсын Их Хурлын гишүүдэд чинь төсөв зарах эрх байхгүй шүү дээ.

Бусад Улсын Их Хурлын гишүүдэд чинь захиргааны том бүтцийг захиргаадах эрх байхгүй шүү дээ.

Бусад Улсын Их Хурлын гишүүд чинь ний нуугүй хэлэхэд.../минут дуусав/

Б.Жавхлан: Одоо хэдүүлээ санал хураалт руугаа оръё. Гишүүд анхааралтай байгаарай.

Зарчмын зөрүүтэй санал хураалт үргэлжилж байгаа учраас бэлтгэх шаардлагагүй юм байна шүү. Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 17 гишүүн оролцож 10 гишүүн зөвшөөрч, 58.8 хувиар санал дэмжигдлээ.

10.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 27 дугаар зүйлийн 27.15 дахь хэсгийн “дэд хорооны бүрэлдэхүүнд” гэснийг “Халдашгүй байдлын дэд хорооноос бусад дэд хорооны бүрэлдэхүүнд” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал.
Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 17 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 70.6 хувиар санал дэмжигдлээ.

11.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр 9 дэх заалт буюу 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг бүхэлд нь хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 61.1 хувиар дэмжигдлээ.

Уг санал дэмжигдсэнтэй холбоотойгоор тайлбар. 11 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан нэгтгэсэн төслийн 1 дүгээр 9 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсгийг нийцүүлэн өөрчилнө.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 61.1 хувиар дэмжигдлээ.

12.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийн “эцсийн хэлэлцүүлгийн” гэснийг “хууль, тогтоол батлах, эцэслэн батлах, хэлэлцүүлгийн” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 72.2 хувиар дэмжигдлээ.

13.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалт буюу 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 72.2 хувиар дэмжигдлээ.

14.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 77.8 хувиар дэмжигдлээ.

Уг санал дэмжигдсэнтэй холбогдуулж тайлбар. 14 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн, мөн зүйлийн 25.7 дахь хэсгийн “сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно” гэснийг “сонгоно” гэж гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 72.2 хувиар уг санал дэмжигдлээ.

Гишүүд анхааралтай байгаарай.

Энэ нөгөө олон яригдаад байсан саналын томьёолол уншлаа шүү.

15.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.10 дахь хэсгийг 15.10, 15.11, 15.12 дахь хэсгийг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслийн дугаарыг өөрчлөх:

15.10.Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний ажлыг хавсран хийж буй бол нэгдсэн хуралдааны танхимын дунд байрлах мэтгэлцэх индрийн харалдаа нүүрэн хэсэгт сөрөг хүчний намын даргын суудалдаа харгалзуулан Ерөнхий сайдын суудлыг Засгийн газрын гишүүдийн суудал дээр бөөнд нь хуваарилна.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Т.Тэмүүжин. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 4 гишүүн дэмжиж, 22.2 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

16.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.5, 15.6, 15.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

15.5.нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн зүүн гар талд олонхын бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд нүүрний эгнээнд олонхын бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргын суудлын дараагаас олонхын бүлгийн дарга эрх барих хүчнээс сонгогдсон Ерөнхий сайд хэрэв Улсын Их Хурлын гишүүн бол түүний суудлыг дараалуулан хуваарилна.

Олонхын бүлгийн бусад гишүүд нэгдсэн хуралдаанд хүрэлцэн ирсэн дарааллаараа олонхын бүлгийн гишүүдэд хуваарилагдсан бусад аль ч суудалд сууж хуралдаандаа оролцож болно.

15.6.нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн баруун гар талд хамгийн олон суудал авсан цөөнхийн бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд нүүрний эгнээнд тус бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргын суудлын дараагаас цөөнхийн бүлгийн даргын суудлыг хуваарилна.

Хамгийн олон суудал авсан цөөнхийн бүлгийн бусад гишүүд нэгдсэн хуралдаанд хүрэлцэн ирсэн дарааллаараа цөөнхийн бүлгийн гишүүдэд хуваарилагдсан бусад аль ч суудалд сууж хуралдаандаа оролцож болно.

15.7.цөөнх болсон бусад нам, эвслийн бүлгийн гишүүд бүлэггүй цөөнхийн гишүүдийг дараагийн суудлуудад хуваарилах бөгөөд тус цөөнхийн бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд дарга тухайн цөөнхийн бүлгийн дарга нарын суудлыг нүүрний эгнээнд тус тус хуваарилна.

Цөөнх болсон бусад нам, эвслийн бүлгийн болон бүлэггүй цөөнхийн бусад гишүүд нэгдсэн хуралдаанд хүрэлцэн ирсэн дарааллаараа тэдгээрт хуваарилагдсан бусад аль ч суудалд сууж хуралдаандаа оролцож болно.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал. Санал хураалт.
/алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 1 гишүүн дэмжиж, 5.6 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Хоёр.Төслийн 2 дугаар зүйлтэй холбоотой саналууд.

17.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын “томьёоллоо” гэсний дараа “хуулийн шаардлагад нийцүүлэн томьёолж гэж” гэснийг хасаж, төслийн 4 дүгээр зүйлд 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын “зарчмын зөрүүтэй саналын томьёоллоо холбогдох Байнгын хороонд ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө” гэснийг зарчмын зөрүүтэй саналын томьёоллоо. уучлаарай. Хуулийн шаардлагад нийцүүлэн томьёолж, холбогдох Байнгын хороонд ажлын нэгээс доошгүй өдрийн өмнө гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 44.4 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

18.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн 21 дүгээр зүйлийн 21.20 дахь хэсгийн мэтгэлцээн явуулна гэсний дараа мэтгэлцээн явуулах журмыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тогтооно гэснийг хасаж, 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмж нэгтгэсэн төслийн холбогдох дугаарыг өөрчлөх.

21.20.нам, эвслийн бүлэг, эсхүл Улсын Их Хуралд суудал бүхий намаас мэтгэлцээн явуулах санал гаргасан бол чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх эсэх үе шатад мэтгэлцээн явуулна. Мэтгэлцээн явуулах журмыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тогтооно.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 44.4 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт сулраад байна шүү.

19.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн мөн зүйлийн 27.8 дахь хэсгийн “саналыг баримтална” гэсний дараа “Ёс зүйн дэд хороо 9 гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын дэд дарга нар заавал орно” гэснийг “саналыг баримтална гэсний дараа Ёс зүйн дэд хороо 9 гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын дэд дарга нар орно” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар уг санал дэмжигдлээ.

20.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн мөн зүйлийн 27.10 дахь хэсгийн “сонгоно” гэсний дараа “Ёс зүйн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын аль нэг дэд даргыг дэд хорооны гишүүд дотроосоо сонгоно” гэж гэснийг хасаж нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлд мөн зүйлийн 27.10 дахь хэсгийн “сонгоно” гэснийг “эсхүл Улсын Их Хуралд суудал бүхий намын гишүүдээс сонгоно. Ёс зүйн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын аль нэг дэд даргыг дэд хорооны гишүүд дотроосоо сонгоно” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж Б.Энхбаяр гишүүний микрофон. Үг хэлнэ.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтцийг хуулиар тогтооно гэсэн Үндсэн хуультай байгаа.

1999, 2000 оны өөрчлөлтөөр “Улсын Их Хурлын дэд дарга” гэдэг нэршил албан ёсоор Үндсэн хуульд бичигдсэн. Парламентад суудалтай бүлгүүдийг төлөөлж дэд даргатай байна гээд бүлэг болгонд парламентад дэд даргатай байна гэдэг ийм өөрчлөлт бол 2000 онд Үндсэн хуульд орж нутагшсан байдаг.

Дэд дарга өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд парламентын хоорондын найрамдлын бүлгүүд хуралдааны дэг сахиулах, ирц ахиулах, бүлэг хоорондын хамтын ажиллагааны асуудлыг хариуцаж ирсэн байдаг.

Одоо энэ хуульд Улсын Их Хурлын дэд дарга бөгөөд Ёс зүйн дэд хороон дарга болох гэж байгаа юм байна.

Тэгэхээр парламентынхаа дэд дарга нь дэд хороон дарга байна гэдэг нэг хүнд Улсын Их Хурал дотроо давхар дээл өгөх гэж байна гэсэн үг л дээ.

Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний үүрэгт ажлыг хавсарч эрхлэхийг Үндсэн хуулиар зөвшөөрсөн.

Энэ хууль бол Улсын Их Хурлын гишүүнийг Улсын Их Хурал дотроо давхар албан тушаал хашихыг нь зөвшөөрөх гээд байна. Нэг хүнд. Дэд дарга бөгөөд Ёс зүйн дэд хороон дарга болгох гээд байна л даа. Тэгээд энэ зарчим нь өөрөө зөв үү? Улсын Их Хурлын дарга бөгөөд Байнгын хороон дарга гэж байж бол байхгүй л байх л даа. Бодвол. Яг түүнтэй адилхан сонсогдоод байна шүү дээ.

- Бүлгийн дарга,
- Улсын Их Хурлын дарга,
- Улсын Их Хурлын дэд дарга,
- Байнгын хорооны дарга нар чинь –

-өөр ажил хавсардаггүй шүү дээ. Их Хурал дотроо. Ийм үүд хаалга нээгээд явчих юм биш үү? Би анх удаа л ийм юм сонсоод байна л даа.

Улсын Их Хурлын бүтцийн албан ёсны дэд дарга нь Улсын Их Хурлынхаа бүтцийн дахиад нэг дэд хорооны дарга хавсарч хийнэ гэдгийг бид хуульчлах гээд байна шүү дээ.

Улсын Их Хурлын бүтцийнхээ нэгжийн даргыг парламент өөрсдөө сонгодог байх нь зөв юм биш үү? Энэ чинь сонгуульт албан тушаал биз дээ.

- Улсын Их Хурлын дэд даргыг 4 жилийн хугацаагаар сонгодог.

- Байнгын хорооны даргыг 1 жилээр сонгодог.
- Дэд дарга дээр хугацаа байдаггүй.

Б.Жавхлан: Хууль санаачлагчийг төлөөлж Аюушын Ариунзаяа гишүүн тайлбар хэлнэ.

А.Ариунзаяа гишүүний микрофоныг нээе.

А.Ариунзаяа: Нэгдүгээрт яг энэ санал хураалт нь Улсын Их Хурлын дэд даргыг Ёс зүйн дэд хорооны даргаар сонгох уу, үгүй юу гэдгийг шийдэх гээд байгаа асуудал биш буюу хууль санаачлагч анхнаасаа оруулж ирэхдээ аль нэг дэд дарга нь буюу дэд дарга манай хууль дээр чинь олонхын талаас дэд дарга гэж байгаа билүү, нэг дэд даргаа Ёс зүйн дэд хорооны даргаар сонгоно гэсэн ийм хуулийн төслийг хууль санаачлагч анхнаасаа өргөн барьсан.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Улсын Их Хурлын хуулийн 14.4 дээр Улсын Их Хурлын дэд даргын чиг үүргүүдийг тодорхой заагаад өгсөн байгаа.

Тэгээд энэ дотроо 14.4.2 дээр Улсын Их Хурлын үйл ажиллагааны дэг гишүүний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үүргийг хүлээж байгаа учраас өөрөө дотооддоо яг энэ ёс зүйн дэд хороогоо бас ахлаад, ингээд Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд нь гишүүдийнхээ ёс зүйн хэм хэмжээнд нь хэрэгжилтийг нь хянах ийм үүргийг хүлээхээр энэ албан тушаалтныг Ёс зүйн дэд хорооны дарга байхаар оруулж ирсэн.

Тэгээд ер нь энэ бас амьдралаас гарч байгаа практик нь юу вэ гэхээр ер нь Улсын Их Хурлын гишүүд бие биедээ ёс зүйн хэм хэмжээний шаардлага тавихад энэ юугаараа надаас илүү ёс зүйтэй юм гэдэг ийм асуудлуудыг тавиад байгаа учраас анхнаасаа Улсын Их Хурлын дэд дарга нараа сонгохдоо ёс зүйтэй хүмүүс сонгогдох ёстой.

Тэгээд эдгээр хүмүүс нь албан тушаалаараа ч тэр, өөрсдийн ранкаараа ч тэр бусад гишүүдийнхээ ёс зүйн хэм хэмжээг хянаж байх, хэрэгжилтийг нь хангуулж байх ийм үүргийг хүлээнэ гэсэн ийм хууль санаачлагчийн асуудал байгаа юм гэдгийг онцлон хэлье.

- Хууль зөрчсөн асуудал байхгүй.
- Үндсэн хуулийг зөрчсөн асуудал байхгүй.

Б.Жавхлан: Дэгээрээ явъя. Асуулт асууж хариулт авсан. Санал хураалт. /алх цохив/

18 гишүүн санал хураалтад оролцож, 8 гишүүн дэмжиж, 44.4 хувиар санал дэмжигдсэнгүй.

21.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн “мөн зүйлийн 27.8 дахь хэсгийн саналыг баримтална” гэсний дараа “Ёс зүйн дэд хороо 9 гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын дэд дарга нар заавал орно гэж” гэснийг хасаж, нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлд 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсгийн “нам, эвслийн бүлгийн саналыг баримтална” гэснийг “нам, эвслийн бүлэг, эсхүл Улсын Их Хуралд суудал бүхий намын саналыг баримтлана. Ёс зүйн дэд хороо 9 гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын дэд дарга нар орно” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар.

Энэ ажлын хэсэг дээр дэмжигдээгүй санал шүү. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 2 гишүүн дэмжиж, 11.1 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

22.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн 44 дүгээр зүйлийн 44.1.13 дахь заалтын “ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл” гэсний дараа “хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх гэж” гэснийг 44 дүгээр зүйлийн 44.1.13 дахь заалтын “ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл ашиг сонирхлын зөрчилтэй гэж үз. Энэ чинь 2 дахин биччихсэн байгаа юм. Энэ найруулга нь зөв үү? Ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл. Ингэж унших юм уу?

Редакцын алдаа гаргасан байна. Дахиад уншъя.

22.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийн 44 дүгээр зүйлийн 44.1.13 дахь заалтын “ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл” гэсний дараа “хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх гэж үзсэний” гэснийг 44 дүгээр зүйлийн 44.1.13 дахь заалтын “ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл хянан шалгах чиг үүрэг бүхий ажлын хэсэг Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах” гэснийг “ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, хянан шалгах чиг үүрэг бүхий ажлын хэсэг Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллах хууль тогтоомжийн төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргах” гэж өөрчлөн нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйл рүү шилжүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал. Санал хураалт. /алх цохив/

18 гишүүн санал хураалтад оролцож, 2 гишүүн дэмжиж, 11.1 хувиар санал дэмжигдсэнгүй.

Гурав.Төслийн 3 дугаар зүйлтэй холбоотой саналууд.

23. гишүүд. Анхааралтай байгаарай.

Одоо дэгээрээ явна шүү. Одоо 3 дугаар зүйлүүдийг уншихаас өмнө Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Нэрээ өгнө. Санал хураалтыг хаагаарай. Техникийн албаныхан гацчихлаа шүү.

Ж.Батжаргал гишүүнээр тасаллаа. 4 гишүүн байна. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Гаргасан санал нь ажлын хэсэг, Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин.

Х.Тэмүүжин гишүүн ажлын хэсэгт байгаа юм уу? Байхгүй. Тусдаа гаргаад байгаа юм уу? Дэмжсэн юм уу?

Үгүй ээ, энэ одоо ерөөсөө бүр.

Улс төрч хүнд байна шүү дээ. Ямар нэгэн улс төрч хүнийг ард түмэн л шүүдэг, дүгнэдэг. Тийм ч учраас улс төрийн ёс зүй гэж байдаг.

Тийм учраас сонгуульт албан тушаалтан гэж яригддаг. Хариуцлагыг нь сонгуулиар ард түмэн эргээд тавьдаг. Сонгосон хүндээ дүнг нь сонгуулиар тавьдаг.

Адилхан Улсын Их Хурлын гишүүн хүн гишүүд гарч ирж нэгнийхээ үгийг хязгаарлах, юу хэлж болохгүйг нь хуулиар заах ийм хууль батлах гээд байх юм. Санал гаргаад байх юм. Би ерөөсөө үүнийг ойлгохгүй.

Парламентад аюул занал учирлаа. Парламентын дархлаа. Парламентын дархлаа гэж юу юм бэ. Парламентын дархлаа гэдэг чинь энэ Улсын Их Хурлын гишүүдийн үгээ хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх энэ эрх чөлөө байхгүй юу даа. Яагаад гэхээр энэ хүмүүс өөрсдийгөө өмнөөс биш өөрийг нь сонгосон ард түмний сонгогчдыгоо төлөөлж ярьж байгаа учраас. Сонгогчдоо төлөөлөөд байгаа байхгүй юу. Сонгогчид чинь янз бүрийн хүсэл, шаардлага тавьж болно, бодлого хэлж болно, уурлаж болно. Бухимдлыг нь тэр ард түмний төлөөлөгчийг илэрхийлэх ёстой байхгүй юу. Илэрхийлж байх ёстой. Тэрийг нь хаагаад байх юм.

Одоо жишээлбэл Улсын Их Хурлын гишүүн, Их Хурлын дарга ч юм уу, Байнгын хорооны дарга ч юм уу энэ хүмүүс чинь бас Их Хурлын гишүүн сонгогчидтой хүмүүс шүү дээ. Ардаа.

Намын бодлого илэрхийлж болохгүй, ашиг сонирхлыг илэрхийлж болохгүй. Энэ нэг барих барьцгүй. Үүнийг яг хэн шүүх юм? Энэ хүн яг өөрийнхөө дотроос ярьж байна. Энэ хүн яг нам нь яг яриад байна. Энэ яг сонгогч Балдангийн үгийг хэлээд байна гэдгийг хэн шүүх гээд байгаа юм бэ? Энэ одоо ийм санал гаргаад байх юм.

Энэ чинь харин эсрэгээрээ парламентын ардчилалд чинь заналхийлж байгаа шүү дээ.

► “Парл” гэдэг үг чинь “ярих” гэсэн утгатай латин үг шүү дээ.

■ “Парл” гэж парламентын чинь үгийн үндэс нь. “Ярьдаг, хэлдэг газар” гэсэн утгатай үг байхгүй юу. Энэ парламент гэдэг чинь. Ярьдаг, хэлдэг. Тэр ярьдаг, хэлдэг үгийг нь хаах санал гаргаад байх юм.

Тийм учраас энэ өөрөө Үндсэн хуульд нийцэж байгаа юм уу? Энэ санал өөрөө. Энэ бүр санал хураах ёстой санал мөн юм уу? Тэгвэл бүр.

Яагаад гэхээр Үндсэн хуулиар ард түмний сонгогдсон тэр Улсын Их Хурлын гишүүний үг хэлэх эрх чөлөөг нь хязгаарлаад байна шүү дээ.

— Чи ийм юмаар л ярьж болно.

— Ийм юмаар ярьж болохгүй гээд.

Хэн болсон юм. Хамгийн их ардчилал ярьчихаад ардчиллынхаа эсрэг санал гаргаад суугаад байх юм.

Б.Жавхлан: Хууль санаачлагч нь Х.Тэмүүжин гишүүн. Тийм ээ. Гишүүн үг хэллээ.

Дараагийн гишүүн. Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Х.Тэмүүжин гишүүн болон Ардчилсан нам, нэлээд олон гишүүд Улсын Их Хурлын даргын нам бус байхтай холбоотой хуулийн төсөл санаачлан өргөн барьсан.

Өргөн барих эрх нь байгаа. Үүнийг хэрхэн яаж засах вэ гэдэг нь Та бидний өмнө хүлээсэн үүрэг байна гэдгийг онцлон хэлье.

Хоёр дахь нь болохоор надад яг энэ ажлын хэсэг Байнгын хороодын тоог нэмэгдүүлээд санал гарсан нь буруу юм биш үү. Үүнийг бид бас анхаарах хэрэгтэй байна гэдгийг онцлон хэлье.

Одоо 11 Байнгын хороо 12 Байнгын хороо болоод ирэхээр Байнгын хороодын гишүүдийн тоо нь хүртэл 19 гэж орж ирээд. 76 гишүүнтэй байхад 19 гишүүнтэй Байнгын хороод байсан шүү дээ.

Тэгээд ер нь яагаад Байнгын хорооны гишүүдийн тоотой нь холбоотой төлөөлөх зарчим алдагдаад байна. Нөлөөлөлд автах хүмүүсийн тоо гэдэг ч юм уу, Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ тоог нэмэгдүүлэх нь хүртэл яг үүнтэй холбоотой байсан байхгүй юу.

Нэг Байнгын хороонд 19 гишүүн байхаар 10 гишүүнээр ирц бүрдээд 5, 6 хүнээр саналууд дэмжигдээд явах байхгүй юу. Эсвэл унах, эсвэл дэмжигдэх.

Тэгэхээр ер нь төлөөллийн ардчилал талдаа ч гэсэн энэ маш сөрөг.

Тэгэхээр уг нь бид Байнгын хороодынхоо тоог нэммээргүй байна. Ажлын хэсэг үнэхээрийн Аж үйлдвэржилтийн байнгын хороог байх нь зүйтэй гэж үзсэн бол өөр ямар Байнгын хорооны оронд байж болох вэ гэдэг ч юм уу? Энэ агуулгаар нь харсан илүү зөв байх байсан юм.

Тэгээд бид ер нь хүнд зориулж аливаа Байнгын хороодыг бий болгодог, нэрийг нь өөрчилдөг ийм нөхцөл байдлаа болимоор байна. Хэдий хүртэл хэн нэгэн хүнд зориулах юм бэ. Улс орноо бодмоор байна шүү дээ.

Тэгэхээр энэ асуудал дээрээ бас анхааралтай байж саналаа өгөхдөө тухай бүр нь анхаарч хараасай гэж хүсэж байна. Ямар ч байсан 3 дугаар зүйлтэй холбоотой Байнгын хороодын тоо болон нэр нэг Байнгын хороонд харьяалагдах гишүүдийн тоотой холбоотой дэмжихгүй байх ийм саналтай байна.

Б.Жавхлан: Гишүүн үг хэллээ. Дараагийн гишүүн. Б.Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Энэ хуулийн зарчмын зөрүүтэй саналуудыг харлаа. Орж байгаа нэмэлт, өөрчлөлтүүдийг харж байна.

Бид нар ч ер нь тэгээд “бушуу туулай борвиндоо баастай” гэдэг байдлаар л энэ хуулийн төсөл орж ирж байна уу даа л гэж харж байна.

Их Хурлын тухай хууль, дэгийн тухай хууль, хяналт шалгалтын тухай хууль дээр янз бүрийн байдлаар нэмэлт, өөрчлөлт нэрээр сэглээд. Бараг өмнөхөөсөө зарим зүйл, заалтууд нь дордож байх шиг байна.

Байнгын хороог ер нь бид хүнд зориулж байгуулдгаа ер нь хэзээ болих юм. Хэдхэн сарын өмнө энэ 3 Байнгын хороодыг чинь татан буулгасан шүү дээ.

Би тэгэхэд Ёс зүй, дэгийн байнгын хороон дарга байсан. Тэгээд энэ Цахим бодлогын байнгын хороо ч билүү, Аж үйлдвэржилтийн байнгын хороо. Хэнд ч хэрэггүй Байнгын хороо, хүнд зориулж байгуулсан Байнгын хороо гээд л элдвээр нь хэлсээр байгаад л тэгээд л гурвууланг нь татан буулгасан. Одоо буцаад Ёс зүйн дэд хороогоо байгуулах гээд л энэ хуулийн төсөл дээр чинь чадахгүй мунгинаад л хэрэлдээд сууж байна шүү дээ.

Дэд дарга байна, байхгүй гээд л. Тэгсэн мөртлөө нийгмийн үнэ хүлээлтэд өндөр байгаа ёс зүйгээ бид уг нь илүү өндөр түвшинд ярьж гэхээр Байнгын хороог нь татан буулгачихна. Хэрэггүй гээд. Тэгээд дараа нь дэд хороогоо ч нэг их олигтой байгуулж байгаа юм байхгүй. Тэгээд буцаагаад 2 Байнгын хороог нь шинээр дахиад байгуулъя гээд санал оруулаад ирж байгаа юм.

Тэгээд үүнийг дэмжих ямар ч боломж байхгүй. Тэгээд үнэхээр тэр салбар чиглэл нь хэрэгтэй байсан юм бол тэгвэл өмнө нь яах гэж татан буулгасан юм. Их Хурал ядаж энэ санах ойгоо ядаж нэг жилээс дээгүүр байлгамаар байна шүү дээ.

Жилийн дотор татан буулгаснаа буцаагаад байгуулдаг Байнгын хороо гэж ер нь юу байдаг юм? Энэ иргэд чинь харж байгаа шүү дээ.

Тэгээд хэн нэгэнд албан тушаал өгөхийн тулд, нэг дарга сэтэр зүүлгэхийн тулд. Дарга сэтэр зүүхгүй бол үхчих гээд байгаа юм уу? энэ Улсын Их Хурлын гишүүд чинь. Тэгээд энэ Байнгын хороо чинь ардаа төсөвтэй. Хөөе. Энэ төсвийн татвар төлөгчдийн мөнгөөр гаргадаг юм. Үүнийг ямар ч дэмжих боломж байхгүй.

Ер нь энэ ил тод нээлттэй ярилцаж байх ёстой. Энэ асуудлаа. Тэгээд өмнө нь болохоор хэрэггүй хэрэггүй гэж татан буулгачхаад одоо тэгээд буцаагаад байгуулна гээд санал оруулж ирээд. Аливаа асуудалд бас нэг жоохон цензуртэй хандах хэрэгтэй байх.

Б.Жавхлан: Гишүүн үг хэллээ.

Дараагийн гишүүн Ж.Батжаргал дарга. Гишүүний микрофоныг нээе.

Ж.Батжаргал: Хууль зүйн техник талаасаа их сонин болчхоод байгаа юм.

Төсөл өргөн барихдаа нэг санал дэвшүүлчхээд, түүн дээрээ өөрөө зарчмын зөрүүтэй санал гаргачхаад, тэр зарчмын зөрүүтэй санал нь хоорондоо ярьж хөөрсөн гэж сая Х.Тэмүүжин гишүүн тэгээд байна шүү дээ. Өөрөө.

Тэгэхээр зэрэг Улсын Их Хурлын дарга бол нам бус байж болно. Хурал удирдаж байхдаа төвийг сахина гээд ийм тодорхой хэдэн юм тохирсон юм билээ.

Гэтэл нөгөө хоёр дээрээ өмнөх юунуудаа аваачиж хийгээд нэг саналын томьёолол болгохоор чинь өнөө тохирсон юмыг нь авч үлдэх гэхээр зэрэг болохгүй болчхоод байгаа байхгүй юу. Тэгээд үүнийг одоо ер нь яах ёстой юм бэ? Одоо жишээ нь энэ 23 дугаар саналын томьёоллыг чинь уншихаар яг ингэж орж ирээд байгаа байхгүй юу.

Дараагийн нэг асуудал бол тэр угаасаа ярьж хөөрсөн байсан учраас нэгдсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 11 дүгээр зүйлийг бол хасах ёстой юм бид. Тэглээ гэж ойлгож орж ирсэн. Одоо ингээд энэ чинь хууль зүйн техник болоод байгаа байхгүй юу. Энэ 23 дугаар саналыг бид унагачихна.

Тэгэхээр төсөл үлдчихэж байгаа байхгүй юу. Тийм биз дээ.

Анхны өргөн барьсан төсөл үлдчихэж байгаа юм.

Тэгэхээр тэр дотор чинь түрүүний яриад байдаг бүх юм чинь байгаа шүү дээ. Иргэдтэй уулзахдаа намын тухай юм ярьж болохгүй тухай. Юу руу орохдоо бүлгийн нөхдүүдээс зөвшөөрөл авах тухай гээд баахан юм байгаад байгаа шүү дээ.

Тийм учраас энэ үүднээс нь хандаж хасах ёстой. Би ийм томъёолол гарна гэж бодолгүйгээр анхны төсөл дээр нь тулгуурлаж зарчмын зөрүүтэй саналаа 6 сарын 11-нд байх аа. 10-нд билүү, 10-нд Байнгын хороондоо гаргасан.

Тийм учраас энэ талаасаа асуудалдаа хандаж шийдвэрлэх нь зүйтэй юм гэж хэлмээр байна.

Б.Жавхлан: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалтын ирцийн бүртгэлийг нь шалгачихъя. Гишүүд санал хураалтдаа бэлтгэнэ үү. Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалтынхаа ирцэд орох хэрэгтэй байна. О.Алтангэрэл гишүүн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн, Ж.Баярмаа гишүүн, А.Ганбаатар гишүүн, Л.Гантөмөр гишүүн, Л.Мөнхбаатар гишүүн, Э.Одбаяр гишүүн, Н.Учрал гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Б.Энхбаяр гишүүн ирцдээ ороорой.

Санал хураалтын ирцэд. Төхөөрөмжөө идэвхжүүлээрэй. Санал хураалтад бэлдэнэ үү.

Гишүүд анхааралтай байгаарай. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол уншлаа шүү.

32.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Их Хурлын даргад” гэснийг “Улсын Их Хурлын даргад” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал.

33.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Улсын Их Хурлын дарга Олон улсын парламентын холбоо, хоорондын тохиролцсон албан тушаалаас өөр ажил албан тушаалд давхар эрхлэхийг хориглоно” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал.

34.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 11 дүгээр зүйлийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Ж.Батжаргал.

Гишүүд анхааралтай байгаарай.

Сая санал гаргасан учраас горимоороо дэгээрээ уншиж танилцуулчихлаа. Одоо ингээд 23-аас эхлээд санал хураалттай шүү. Анхааралтай байх хэрэгтэй.

23.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

11.1.Олонх Улсын Их Хурлын даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно.

11.2.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлыг Даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно.

11.3.Нэр дэвшигч хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэг авч чадаагүй бол энэ хуулийн 11.1-т заасны дагуу өөр гишүүний нэрийг дэвшүүлж сонгоно.

11.4.Улсын Их Хурлын дарга нь төвийг сахисан бие даасан байр сууриас бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас өөр албан тушаал давхар эрхлэхийг хориглох бөгөөд гадаад улсад гагцхүү Улсын Их Хурлыг төлөөлнө.

11.5.Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 11.4-д заасан төвийг сахисан бие даасан байр сууриас бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд намын улс төр төрөөс ангид байх бөгөөд дараах хязгаарлалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

11.5.1.Улсын Их Хурал дахь аль нэг нам, эвслийн бүлгийн хуралдаанд оролцох бол Улсын Их Хурал дахь олонх, цөөнх бүлэг, бүлэггүй намын Улсын Их Хурал дахь удирдлагад мэдэгдэнэ.

11.5.2.бүрэн эрхийн хугацаандаа улс төрийн намын даргын сонгуульд өрсөлдөхгүй, намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцохгүй.

11.5.3.хэвлэл, олон нийттэй харилцахдаа Улсын Их Хурлын даргын төвийг сахисан байр суурийг алдагдуулж, улс төрийн намыг төлөөлөх, намын бодлого, ашиг сонирхлыг илэрхийлэхийг хориглоно.

11.6.Энэ хуулийн 11.5-д заасан хориглолт, хязгаарлалт нь Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын дараагийн ээлжит болон ээлжит бус сонгуульд намаасаа нэр дэвшиж сонгуулийн сурталчилгаа хийх эрхийг хязгаарлахгүй.

Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин. Санал хураалтад бэлэн үү. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 1 гишүүн дэмжиж, санал 5.6 хувиар дэмжигдсэнгүй.

Саяын санал хураалтын дүнтэй холбогдуулж дараагийн зочин зөвлөлийн санал дээр очиж байна шүү. Гишүүд анхааралтай байгаарай.

34.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 11 дүгээр зүйлийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Ж.Батжаргал. Санал хураалт. /алх цохив/

Б.Хэрлэн гишүүн горимын санал гаргах юм уу? Тийм ээ. Б.Хэрлэн гишүүний микрофоныг нээе.

Б.Хэрлэн: Төхөөрөмж дээр саатал гарсан учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү. Ахин санал хураалт явуулъя.

Б.Жавхлан: Баярлалаа. Саяын Б.Хэрлэн гишүүний гаргасан горимын саналаар сүүлийн санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

18 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар Б.Хэрлэн гишүүний гаргасан горимын санал дэмжигдэж, саяын санал хураалт хүчингүй боллоо.

Одоо дахин санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар уг санал дэмжигдлээ.

Б.Хэрлэн гишүүний микрофоныг нээе. Үг хэлэх юм байна. Тийм ээ?

Б.Хэрлэн: Тэгэхээр хуулийн төсөлд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаатай холбоотой 41.9 дүгээр зүйл, заалтын үндэслэлийг авахдаа энэ дээр Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1-д заасны дагуу тэтгэмж олгох бөгөөд тэтгэмжтэй олгохтой холбогдсон журмыг энэ хуулийн 47.4-д заасан захирамжаар батална гээд оруулаад ирсэн байна л даа.

Энэ дээр Б.Жавхлан дарга аа, С.Бямбацогт дарга аа, энэ дээр ингэж байгаа юм л даа. Нэгдүгээрт энэ чинь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн тухай асуудлыг ярьж байхад энд бид Хөдөлмөрийн хуулийг барих нь зохимжгүй байх аа.

Хоёрдугаарт, Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1 дэх хэсэг дээр чинь ямар үндэслэлээр тэтгэмж өгдөг юм бэ гэхээр ажлын байр нь хасагдсан, орон тоо цөөрсөн, ажил үүрэгтэй тэнцэхгүй болох нь тогтоогдсон, эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон үед нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч нь тэтгэмж өгдөг тухай ийм үндэслэл байгаа байхгүй юу.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх дуусгавар болсны дараагаар олгож байгаа тэтгэмжийн тухай асуудлыг ийм юман дээр үндэслэж хийх юм бол тэр чинь нэгдүгээрт хөдөлмөрийн хуульд бид нарын сонгогдсон улс төрийн түшээд, энэ чинь хөдөлмөрийн харилцаа энд байхгүй.

Тэгэхээр манай ажлын хэсгийн дүгнэлтийг өгсөн юм. Энд. Тэгээд энэ ажлын хэсгийн дүгнэлтээр энэ дээр өөрчилж болох уу? Ажлын хэсгийн дүгнэлтийг би нэлээн дээр өгсөн юм. Тэгээд үүнийг эргэж харж болох уу? Тэгэхгүй бол яг одоогийн төслөөр орж ирэх юм бол хууль тогтоогчид өөрөө энэ их тийм сонин юм болох гээд байна. Энэ чинь аягүй сонин юм болох гээд байна шүү.

Б.Жавхлан: А.Ариунзаяа гишүүн хариулна.

А.Ариунзаяа: Б.Хэрлэн гишүүн ээ, хууль өргөн баригдаад, олон Улсын Их Хурлын гишүүд олон хуулиуд өргөн баригдаж нэгтгэгдээд, ажлын хэсэг байгуулагдаад, хүмүүс зарчмын зөрүүтэй саналуудаа өгөөд, ажлын хэсгүүд ажиллаад, одоо ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж байхад Та үндсэн хуулийнх нь асуудлаар нь асуулт асуугаад, үг хэлээд байх юм.

Та тийм байсан юм бол зарчмын зөрүүтэй саналаа өгөөд, томьёоллоо өгөөд ажлын хэсэг дээрээ хураалгачихгүй яасан юм бэ? Одоо тэгээд яг яая гэсэн үг вэ? Энэ зарчмын зөрүүтэй санал дээр хураалгаж байгаа асуудал таны энэ хөндөөд байгаа яриад байгаа асуудал байхгүй байна. Нэг дээр нь ч байхгүй байна.

Тэгээд Та хэрэв зээ санал байгаа одоо томьёолоод ажлын хэсэгт өгч болох уу, үгүй юу гэдгийгээ асуугаад, тэгээд томьёолуулаад өгчих.

Түүнээс биш одоо яг нөгөө хуулийнхаа нийцлийг тухайн үедээ хэлэлцээд, ярилцаад болсон шүү дээ.

Тэгээд зарчмын зөрүүтэй санал байгаа бол түүнийгээ бичгээр цаасан дээр өгөөд тэгээд саналаа хураалгаад.

Б.Жавхлан: Үгүй ээ, үгүй. Одоо зарчмын суурьтай санал гэж байхгүй шүү дээ.

Байхгүй, байхгүй. Одоо зарчмын суурьтай санал гэж байхгүй шүү дээ.

Одоо энэ чинь бүүр 2 биш, энэ чинь бүр 4 хоног, бараг 5 хоногийн өмнө хаагдсан шүү дээ. Тийм. Одоо зарчмын зөрүүтэй санал байхгүй. Таны үгийг сонслоо. Протоколд тэмдэглэгдлээ шүү дээ. Б.Хэрлэн гишүүн ээ. Шинээр зарчмын суурьтай санал гэж бол байхгүй шүү дээ.

Б.Хэрлэн гишүүн ээ, зарчмын суурьтай санал ажлын хэсэг дээр ирээгүй шүү. Ажлын хэсэг байгуулагдаад, тэрнээс хойш яг хуультай холбоотойгоор зарчмын зөрүүтэй саналд яг таны хэлж байгаа дагуу ирээгүй шүү.

Цаашаагаа явъя. 25.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.6.9 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.9 дэх хэсгийн “цахим хөгжил, хиймэл оюуны бодлогын” гэснийг “инновац цахим бодлогын” гэж өөрчлөх.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 44.4 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

26.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

23.9.Инновац цахим бодлогын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ.

- 23.9.1.дижитал шилжилт, техник технологийн шинэчлэл;
- 23.9.2.цахим засаглалын бодлого, үйл ажиллагаа, цахим дэд бүтэц;
- 23.9.3.мэдээлэл технологийн хөгжил;
- 23.9.4.шуудан, сансар, харилцаа холбооны бодлого үйл ажиллагаа;
- 23.9.5.хиймэл оюуны хөгжил;
- 23.9.6.хиймэл оюуны бодлого, хяналт зохицуулалтын асуудал;

23.9.7.өндөр технологи, инновац, мэдээллийн технологийн үндэсний бодлого;

23.9.8.өндөр технологи, инновац, мэдээлэл технологийн үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого;

23.9.9.өндөр технологи, инновацын дэд бүтэц үйл ажиллагааг хөгжүүлэх бодлого;

23.9.10.өндөр технологи, инновац, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон улсын зах зээлд нэвтрүүлэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого.

Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 33.3 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

27.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.3.7, 23.3.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

23.3.7.шинжлэх ухаан.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 33.3 хувиар уг санал уналаа.

28.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэгт Аж үйлдвэржилтийн байнгын хороо гэж нэмж, төслийн дугаарыг өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 38.9 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

29.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.10.16, 23.10.17, 23.10.18, 23.10.19, 23.10.20 дахь заалтыг хасаж, нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйл доор дурдсан агуулгатай 23.1 дэх хэсэг нэмж, төслийн дугаарыг өөрчлөх:

23.1.Аж үйлдвэржилтийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ.

23.1.1.хүнд үйлдвэрлэлийг дэмжих хөгжүүлэх бодлого;

23.1.2.хүнд үйлдвэрлэл, логистик, дэд бүтэц;

23.1.3.газрын тос, байгалийн хийн асуудал;

23.1.4.түлшний хангамж, нөөцийн бодлого;

23.1.5.ашигт малтмал, түүний суурь судалгаа, хайгуул, ашиглалтын бодлого.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 38.9 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Гишүүний ярьсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол юм байна шүү.

Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалттай холбоотой зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн 22.6.11 дэх заалтын “эрүүл мэнд” гэснийг “хүний хөгжил” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 33.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

30 дугаар зарчмын зөрүүтэй санал юм байна шүү. Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “21” гэж гэснийг “19” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 5 гишүүн дэмжиж, 27.8 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

31.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу 46 дугаар зүйлийн 46.5.6.а дэд заалтыг бүхэлд нь хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 2 гишүүн дэмжиж, 11.1 хувиар санал дэмжигдсэнгүй.

35.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалт буюу 46 дугаар зүйлийн 46.5.5 дахь заалтын “хууль зүйн дүгнэлт” гэснийг “хууль зүйн зөвлөмж” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат. Санал хураалт. /алх цохив/

18 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 33.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

4 рүү орлоо шүү. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбоотой саналууд.

36.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн 8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалтын “Гэр бүлийн гишүүд” гэснийг “хамаарал бүхий этгээд” гэж гэснийг 8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалтын “гишүүн хэлэлцэх гэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол тухайн асуудлаар хэлэлцүүлэг санал хураалтад оролцохоос татгалзах” гэснийг “гишүүн

хэлэлцэх гэж байгаа асуудал нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн ашгийн төлөөх үйл ажиллагаанд төрөөс санхүүгийн дэмжлэг авах, татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэхээр бол тухайн асуудлаар хэлэлцүүлэг санал хураалтад оролцохоос татгалзах” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 41.4 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

37.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн 22 дугаар зүйлийн 22.3.9 дэх заалтын “хууль зүйн зөвлөмж гаргуулах” гэснийг “Байнгын хорооны хүсэлтээр хууль зүйн дүгнэлт, зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээг Тамгын газраар хийлгэх” гэж гэснийг “төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргуулах” гэснийг “төсөл болон төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын талаар Байнгын хорооны хүсэлтээр хууль зүйн дүгнэлт, зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээг Тамгын газар хийлгэх” гэж өөрчлөх.

С.Бямбацогт дарга горимын санал гаргана гэж байна. Микрофоныг нээе.

С.Бямбацогт: Саяын 36 дахь билүү. Санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү. Хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Дэмжиж өгнө үү.

Б.Жавхлан: С.Бямбацогт даргын гаргасан горимын саналаар сүүлийн санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар уг санал дэмжигдэж, сүүлийн санал хураалт хүчингүй боллоо.

Ингээд санал хураалт дахин явуулъя. Санал хураалт. /алх цохив/

18 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар уг санал дэмжигдлээ.

37-г түрүүн уншихсан шүү. Үүнийг дэмжих ёстой шүү. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар уг санал дэмжигдлээ.

38.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийн “ажиллуулж болох бөгөөд тойргоос сонгогдсон гишүүн бие төлөөлөгч туслахтай байж болно” гэснийг “бие төлөөлөгч, туслах тус бүр нэгийг ажиллуулж болно” гэж гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, нэгтгэсэн төслийг 3 дугаар зүйлд шилжүүлэх.

42.5.Гишүүн батлагдсан төсөвт зардалдаа багтаан зөвлөх, туслах, бие төлөөлөгч, туслах, ажиллуулж болно. Тойргоос сонгогдсон гишүүн, бие төлөөлөгч, туслах тус бүр 2-ыг ажиллуулж болно. Гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч, туслахын албан тушаалтны цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал батална.

Санал гаргасан ажлын хэсэг. Энэ дэмжигдсэн санал шүү. Гишүүд анхааралтай байгаарай. Дэмжих юм байгаа шүү. Санал хураалт. Гишүүд дэмжээрэй энэ саналаа.

А.Ариунзаяа гишүүн унагачихлаа.

Саяын гишүүдийн дэмжье гэж байгаа санал наадах чинь аягүй чухал заалтдаа. Гишүүд нэг эргэж харах хэрэгтэй шүү наадхаа. А.Ариунзаяа гишүүн үүнийг эргэж харах хэрэгтэй шүү.

А.Ариунзаяа гишүүн горимын санал гаргая гэж байна.

А.Ариунзаяа: Хууль санаачлагчийн илтгэл унших хэрэгтэй болоод би сая яг гарах гэж байсан амжсангүй. Миний буруу. Энэ санал хураалтыг хүчингүй болгож өгөхийг хүсэж байна.

Б.Жавхлан: А.Ариунзаяа гишүүний гаргасан горимын саналаар саяын сүүлийн санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар сүүлийн санал хураалт хүчингүй боллоо.

Ингээд дахин санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Дахин Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар уг санал дэмжигдлээ.

40.Төсөл зүйл, хэсэг, заалт хасах нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх. Төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Үүнийг дэмжээрэй гишүүд. Үүнийг дагаж байгаа юм шүү. Гишүүд анхааралтай байгаарай. Энэ бас дэмжигдэх ёстой.

Хамт өргөн мэдүүлсэн намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

41.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах.

Санал гаргасан ажлын хэсэг. Үүнийг дэмжих юм шүү. /алх цохив/

Санал хураалтад 18 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар уг санал дэмжигдлээ.

Нэгхэн заалт ч үлдсэн шүү.

39.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлд 27 дугаар зүйлийн 27.3.7 дахь заалтын “Аялал жуулчлалын хөгжлийн, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн, Инновац, цахим бодлогын хөгжлийн, Тогтвортой хөгжлийн зорилгын” гэснийг “Тогтвортой хөгжлийн зорилгын, Эрчим хүчний хөгжлийн” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Санал хураалт. Энэ дэмжээгүй.

18 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрч, 50 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооныхоо гишүүдийн оройн мэндийг хүргэе. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан хэлэлцэх асуудлуудаа хэлэлцсэн байгаа.

Ингээд өнөөдрийн буюу 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сарын 18-ны өдрийн Төрийн байгуулалтын Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 35 минут үргэлжилж, 15 цаг 34 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД